



МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ  
ЭРХ ЗӨВЧЛӨЛ  
ЭНЭ 01 ДУГААР СОРИН 26  
№4 /673/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

166

Монгол Улсын  
ерөнхийлөгчийн  
зарлиг

167

Монгол Улсын  
Тасгийн газрын  
тогтоол

169

**Санхүүжилтийн хэлэлцээр  
соёрхон батлах тухай**

**Ерөнхий шүүгчийн албан  
тушаалд томилох тухай**

**Журам батлах, төлбөрийн  
хэмжээ тогтоох тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

26. Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай 166

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

27. Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай Дугаар 01 166

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

28. Ерөнхий шүүгчийн албан тушаалд томиллох тухай Дугаар 04 167
29. Зарим хүнийг шүүгчийн албан тушаалд томиллох тухай Дугаар 05 167

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

30. Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 271 168
31. Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай Дугаар 273 169
32. Журам батлах тухай Дугаар 277 181
33. Дүрэм, журам шинэчлэн батлах тухай Дугаар 281 186

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ**

34. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эрэлэн шийдвэрлэсэн тухай Дугаар 01 200

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Хөгжлийн бодлогын санхүүжилт-2" хөтөлбөрийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

#### Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Яйчилын Батсуурь, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Алтангэрэл, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дагшээвэгийн Зоригт нарыг тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 2011 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2011 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот**Ерөнхий шүүгчийн албан тушаалд  
томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хөхийсүрэнгийн Батсүрэнг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2011 оны 01 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот**Зарим хүнийг шүүгчийн албан  
тушаалд томилох тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Жавзмаагийн Байгалмааг Архангай аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгчийн, Баясгалангийн Баттулгыг Говьсүмбэр аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгчийн, Пунцагжавын Болормааг Сүхбаатар аймаг дахь Сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 271

Улаанбаатар  
хот

### Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Орон нутгийн чанартай наадам, ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан жишиг хэмжээгээр тооцон төсвөөс олгосон хөрөнгийн хэмжээнд багтаан хуваарилж байхыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 200 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2010 оны 271 дүгээр  
тогтоолын хавсралт

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМД АМЖИЛТ ҮЗҮҮЛСЭН БӨХ, УЯАЧ, ХАРВААЧДАД ТӨСВӨӨС ОЛГОХ БАЙ, ШАГНАЛЫН ЖИШИГ ХЭМЖЭЭ

(мянган төгрөгөөр)

	Улсын наадам	Аймгийн наадам	Сумын наадам
Бөх			
Түрүүлсэн	15.000.0	400.0	150.0
Үзүүрлэсэн	10.000.0	300.0	100.0



Шөвгөрсөн	7.000.0	200.0	70.0
Морь			
Түүрүү	5000.0	400.0	150.0
Аман хүзүү	3000.0	300.0	100.0
Айргийн гурав	2000.0	200.0	90.0
Айргийн дөрөв	1500.0	150.0	80.0
Айргийн тав	1000.0	100.0	70.0
Харваач			
I байр	4000.0	300.0	100.0
II байр	3000.0	200.0	70.0
III байр	2000.0	100.0	50.0

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 10 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 273

Улаанбаатар  
хот

### Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Агаарын тухай хуулийн 25.5, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7.1, 7.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. "Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг 1 дүгээр, Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Агаарын бохирдлын төлбөрийг энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан хэмжээгээр улсын төсөвт төвлөрүүлж хэрэгжилтэд нь

хяналт тавих талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

3. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Сангийн сайд С.Баярцогт нярт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

**Засгийн газрын 2010 оны 273 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт**

**ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ,  
ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйл, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 121 дүгээр зүйлд заасан Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөл (цаашид Зөвлөл гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Агаарын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

**Хоёр. Удирдлага, зохион байгуулалт**

2.1. Зөвлөл нь дарга, орлогч дарга, гишүүдийг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргатай байна.

2.2. Зөвлөлийн дарга нь байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орлогч дарга нь Сангийн дэд сайд, нарийн бичгийн дарга нь байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүрээлэн буй орчны асуудал хариуцсан нэгжийн дарга байна. Зөвлөлийн даргын эзгүйд орлогч дарга зөвлөлийг удирдана.

2.3. Гишүүдийг зөвлөлийн даргын санал болгосны дагуу Ерөнхий



сайд томилж, чөлөөлнө.

2.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Цэвэр агаарын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий гүйцэтгэх захирлыг Зөвлөлийн саналыг үндэслэн томилж, чөлөөлнө. Гүйцэтгэх захирал нь ажлаа байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцаж, хагас жил тутамд үйл ажиллагаагаа Зөвлөлд тайлагнана.

2.5. Цэвэр агаарын сан нь ажлын албатай байна. Ажлын албыг гүйцэтгэх захирал удирдана.

2.6. Цэвэр агаарын сангийн ажлын алба нь гүйцэтгэх захирал, ажилтнуудаас бүрдэнэ. Ажлын албаны орон тооны хязгаар 5 хүртэл байна.

2.7. Зөвлөл болон Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг Цэвэр агаарын сангаас санхүүжүүлнэ.

2.8. Зөвлөл нь холбогдох журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.9. Зөвлөлийн дарга, орлогч дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох урамшууллын хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

#### Гурав. Үйл ажиллагааны чиглэл, хэлбэр

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нийт гишүүдийн хурал байна. Хурлыг Зөвлөлийн дарга удирдана.

3.2. Зөвлөл нь хагас жил тутамд нэг удаа хуралдана. Шаардлагатай бол Зөвлөлийн дарга ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

3.3. Зөвлөлийг хуралдуулах бэлтгэл ажлыг нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна.

3.4. Тухайн хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга тогтоох бөгөөд тухайн асуудлыг хариуцсан гишүүн, иргэн, албан тушаалтан хуралд оруулах бэлтгэлийг хангана.

3.5. Зөвлөлийн хурлаар дараахь асуудлыг хэлэлцэнэ:

3.5.1. цэвэр агаарын сангийн үйл ажиллагаатай холбоотой





дүрэм, журмын төсөл болон тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, асуудалд өгөх зөвлөмж;

3.5.2. Цэвэр агаарын сангийн бүтэц, зохион байгуулалтын талаархи санал;

3.5.3. Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх талаар санал гаргах, гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний төсөл, ажлын удирдамж;

3.5.4. Цэвэр агаарын сангаас санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, тэдгээрийн хэрэгжилт;

3.5.5. агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт дотоодын болон олон улсын байгууллагаас олгож байгаа санхүүжилтийг уялдуулан зохицуулах асуудал;

3.5.6. Цэвэр агаарын санд хөрөнгө хуримтлуулах, зарцуулах болон үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал;

3.5.7. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаа, санхүүжилттэй холбоотой асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх;

3.5.8. энэ журмын 3.10-т заасан ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн ажлын тайлан, мэдээлэл;

3.5.9. Цэвэр агаарын сангийн стратегийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөв болон сангийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан;

3.5.10. хууль тогтоомжид заасан бусад асуудал.

3.6. Хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга 5 хоногийн өмнө хүлээн авч, хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараана.

3.7. Зөвлөлийн гишүүдийн өрсөлдөн эрэлцсэн тэжээлд хурлыг хүчинтэйд тооцох бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн



саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

3.8. Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хуралд иргэн, албан тушаалтан, холбогдох этгээдийг оролцуулж, санал, дүгнэлтийг сонсож болно.

3.9. Зөвлөл нь ажлаа жилээр төлөвлөж, тайлангаа хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

3.10. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл Цэвэр агаарын сангаас санхүүжүүлэх зарим тодорхой асуудлаар холбогдох салбарын эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.

3.11. Зөвлөлийн хурлаас тогтоол, зөвлөмж гаргана. Хурлын явцын дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах асуудлыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

3.12. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, хурал даргалагч баталгаажуулна.

3.13. Хурлын чөлөөт цагт Зөвлөлийн ажлыг дарга, нарийн бичгийн дарга зохион байгуулна.

3.14. Зөвлөлийн гишүүд нь хурлаас гарсан шийдвэрт хамтын хариуцлага хүлээх бөгөөд ажлаа байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүр тайлагнана.

**Засгийн газрын 2010 оны 273 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт**

### **АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

1. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7.1-д заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын олборлосон түүхий нүүрсний килограмм тутамд ногдох агаарын бохирдлын төлбөр нь нэг төгрөг байна.

2. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7.2-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн болон импортлосон органик уусгагчийн агаарын бохирдлын төлбөр нь агаар бохирдуулах хор хөнөөлийн хүчин чадлаас хамааран дор дурдсан 3 зэрэглэлээр килограмм тутамд дараахь хувь, хэмжээтэй байна.



№	БТКУС-ийн код	Бодисын монгол нэршил	Олон улсын нэршил	CAS дугаар	Химийн томъёо	Төлбөр /төгрөг/
Зэрэглэл I						
1	2707.10.00	Бензол: 95%-иас доош хувийн цэвэршилттэй	Benzene	71-43-2	$C_6H_6$	30
	2902.20.00	Бензол: 95% буюу түүнээс дээш хувийн цэвэршилттэй				
2	2903.12.00	Дихлорметан (Метилен хлорид)	Methylene chloride	75-09-2	$CH_2Cl_2$	30
3	2903.19.10	1,1,1-трихлорэтан (метил хлороформ)	1,1,1-trichloroethane	71-55-6	$CH_3-CCl_3$	30
4	2903.22.00	Трихлорэтилен (трихлорэтилен)	Trichloroethylene	79-01-6	$C_2HCl_3$	30
5	2903.23.00	Тетрахлорэтилен (перхлорэтилен)	Tetrachloroethylene	127-18-4	$C_2Cl_4$	30
6	2903.31.00	1,2-Дибромэтан (Этилендибромид ISO)	Ethylene Dibromide	106-93-4	$BrCH_2-CH_2Br$	30



7	2903.39.10	Бромт-метан (метил бромид)	Methyl bromide	74-83-9	CH <sub>3</sub> Br	30
8	2903.39.90	Тетрафторметан	Tetrafluoromethane	75-73-0	(Freon CF <sub>4</sub> 14),	30
9	2903.41.00	Трихлорфторметан	Trichlorofluoromethane	75-69-4	(Freon CCl <sub>3</sub> F 11),	30
10	2903.42.00	Дихлордифторметан	Dichlorodifluoromethane	75-71-8	(Freon CCl <sub>2</sub> F <sub>2</sub> 12),	30
11	2903.49.11	Хлорфторметан	Chlorofluoromethane	593-70-4	CH <sub>2</sub> ClF	30
12	2903.49.11	Дихлорфторметан	Dichlorofluoromethane	75-43-4	(Freon CHCl <sub>2</sub> F 21),	30
13	2903.49.20	Бромхлорметан	Methylene chlorobromide	74-97-5	CH <sub>2</sub> BrCl	30
Зэрэглэл II						
14	2903.14.00	4 хлорт нүүрсгөрөгч	Carbon tetrachloride	56-23-5	CCl <sub>4</sub>	20
15	2901.10.00	Н-Гексан	N-Hexane	110-54-3	C <sub>6</sub> H <sub>14</sub>	20



Зэрэглэл III						
16	2903.13.00	Хлороформ (трихлорметан)	Chloroform	67-66-3	$\text{CHCl}_3$	20
17	2912.11.00	Метанол (Формальде- гид) /Шоргоолжны альдегид/	Formalin	50-00-0	$\text{CH}_2\text{O}$	20
18	2926.90.00	Ацетонитрил /дуухуучийн нитрил/	Acetonitrile	75-05-8	$\text{CH}_3\text{CN}$	20
19	2707.20.00	Толуол: 95%-нас доош хувийн цэвэршилттэй	Toluene	108-88-3	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$	10
	2902.30.00	Толуол: 95% буюу түүнээс дээш хувийн цэвэршилттэй				
	2707.30.00	Ксилол: 95%-нас доош хувийн цэвэршилттэй				
20	2902.41.00	o-Ксилол	O-xylene	95-47-6	-	10
	2902.42.00	m-Ксилол	m-xylene	108-38-3	-	
	2902.43.00	p-Ксилол	p-xylene	106-42-3	-	
	2902.44.00	Ксилолын изомерийн халлимог	Mixed Xylene Isomers	1330-20-7	$\text{C}_8\text{H}_{10}$	
21	2914.11.00	Ацетон	Acetone	67-64-1	$(\text{CH}_3)_2\text{CO}$	10



2207.10.00	Спиртүүд: Этилийн хувилаагүй спирт: 80% буюу түүнээс дээш хатуулагтай	2207.20.00	Этилийн спирт: хувилсан болон бусад спирт	2208.90.10	Этилийн хувилаагүй спирт: 80%-иас бага хатуулагтай	29.05	Цагираг бус спирт ба түүний галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитрожуулсан уламжлал	29.06	Цагираг спирт ба түүний галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитрожуулсан уламжлал	29.07	Фенол: Фенолспирт Фенол буюу Фенолспиртийн галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитрожуулсан уламжлал	3823.70.00	Үйлдвэрлэлийн аргаар гаргасан тосон спирт																																																																																																																																																																																																																																																																																																											
Alcohols:													10																																																																																																																																																																																																																																																																																																											
R-OH													10																																																																																																																																																																																																																																																																																																											
-													-																																																																																																																																																																																																																																																																																																											
22													22																																																																																																																																																																																																																																																																																																											



2909.60.00	Кетонууд: Кетоны хэт исэл тэдгээрийн галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитрожуулсан уламжлал		
2914.12.00	Бутанон (метилэтилкетон)		
2914.13.00	4-метилпентан-2он (метилэобутилкетон)		
2914.19.00	Бусад кетон: Хүчилтөрөгчийн бусад үүрэг бүхий булзгүй цагираг бус	Ketones:	10
2914.21.00	Камфор		
2914.22.00	Циклогексанон ба метилциклогексанон		
2914.23.00	Ионан болон метилнон		
2914.29.00	Бусад кетон: хүчилтөрөгчийн бусад үүрэг бүхий булзгүй циклан, циклен буюу циклотерпений кетон		



2914.3	Хүчилтөрөгчийн үүрэг бүхий аромат кетон	бусад бүлэггүй
2914.40.00	Кетон-спирт ба кетон-альдегид	
2914.50.00	Кетон-фенол ба хүчилтөрөгчийн үүрэг бүхий кетон	бусад бүлэгтэй
2914.70.00	Галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитроэжуулсан уламжлал	
2918.30.00	Альдегидын буюу кетоны үүрэг бүхий карбоксилийн түүний ангидрид, галанд хэт исэл, хэт исэлт хүчил, тэдгээрийн уламжлал	бусад бүлэгтэй
2922.3	Амин-альдегид, амин-кетон	ба амин-оксиген (нэгээс илүү төрлийн хүчилтөрөгчийн үүрэгт булаг агуулснаас бусад); тэдгээрийн давс





24	29.09	Энгийн эфирүүд: Энгийн эфир, энгийн эфир-спирт, энгийн эфир-фенол, энгийн эфир-спирт-фенол, спиртийн хэт исэл, энгийн эфирийн хэт исэл, кетоны хэт исэл, ба тэдгээрийн галогенжуулсан, сульфжуулсан, нитрожуулсан, нитрозжуулсан уламжлал	Ethers:	-	R-O-R	10																	
							25	2905.31.00	Гликолууд (2 атомт спиртүүд, диолууд). Этиленгликоль (этан-диол)	Glycols:	-	R-(OH) <sub>2</sub>	10										
														2905.32.00	Пролиленгликоль (Пропан-1,2-Диол)								
																2909.41.00	2,2-оксидизанол (диэтиленгликоль, Диголь)						
																		2909.43.00	Этиленгликоль буюу диэтиленгликолийн монобутил эфир				
																				2909.44.00	Этиленгликоль буюу диэтиленгликолийн бусад моноалкил эфир		
																						2918.19.00	Фенилгликолийн хүчил, нийлмэл эфир

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2010 оны 10 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 277

Улаанбаатар  
хот**Журам батлах тухай**

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлд завсныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн эргэлтэд хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллахыг холбогдох сайд нарт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД****Ц.НЯМДОРЖ****Засгийн газрын 2010 оны 277 дугаар  
тогтоолын хавсралт****МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС,  
ТЭДГЭЭРИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ  
ЗОРИЛГООР МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОН ХАМТРАН  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон тоног төхөөрөмжийн экспорт, импорт, үйлдвэрлэл, зарцуулалтад хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий



эдийн эргэлтэд хяналт тавих зорилгоор мэдээлэл солилцон хамтран ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Гаалийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Байгалийн ургамлын тухай, Хилийн тухай, Тагнуулын байгууллагын тухай, Эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон холбогдох бусад хууль, энэ журмыг удирдлага болгоно.

1.3. Энэ журмыг хэрэгжүүлэгч нь гадаад харилцаа, эрүүл мэнд, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, мэргэжлийн хяналт, цагдаа, гааль, хил хамгаалах байгууллага байна.

#### Хоёр. Байгууллагын үйл ажиллагаа

Энэ журмыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь мэдээлэл солилцон хамтран ажиллахдаа дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.1. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

2.1.1. хөрш зэргэлдээ улс болон олон улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдлын талаархи мэдээ, мэдээллээр цагдаа, тагнуулын байгууллагыг тухай бүрт хангаж ажиллах;

2.1.2. гадаад улсад энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн талаар цагдаа, тагнуулын байгууллагатай харилцан мэдээлэл солилцон хамтран ажиллах.

2.2. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

2.2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.12.1, 15.12.4-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон талаархи мэдээллийг гааль, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагад хүргүүлж, тухайн байгууллага, аж ахуйн нэгж хаанаас, хэзээ, ямар зориулалтаар, ямар хэмжээний бүтээгдэхүүнийг, ямар боомтоор улсын хил нэвтрүүлэх тухай мэдээлэл болон холбогдох бусад баримтыг эдгээр байгууллагад урьдчилан мэдэгдэх;

2.2.2. шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрөл хүсэгч



нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдолтой эсэх, зөвшөөрөл хүссэн эм, бодисыг ашиглах тоо хэмжээ нь захиалагчийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэх талаар цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагаас лавлагаа, мэдээлэл авах;

2.2.3. мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг эмчилгээний зорилгоор хэрэглэгч, мансуурах донтой этгээдийн нэгдсэн судалгааг улсын хэмжээнд гарган дүгнэлт хийж, хяналтад авсан тухай мэдээллийг цагдаа, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагад улирал тутам хүргүүлэх;

2.2.4. мансуурах донтой этгээдийг цагдаагийн байгууллагатай хамтран албадан эмчлэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх;

2.2.5. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалтад шинээр нэмж оруулах мансууруулах эм, бодисын талаар тагнуул болон цагдаагийн байгууллагаас санал авч, судалгаа хийсний үндсэн дээр Эмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх.

2.3. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

2.3.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны НҮБ-ын конвенцийн 1, 2 дугаар хавсралтад заасан мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисууд /цаашид мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодис гэх/-ыг ашиглах тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгжийн талаархи мэдээлэл, холбогдох баримтыг цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагад хагас жил тутам хүргүүлэх;

2.3.2. тусгай зөвшөөрөл олгохдоо мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл тагнуул, цагдаагийн байгууллагаас холбогдох мэдээлэл авах;

2.3.3. мансууруулах болон сэтгэцэд нөлөөт ургамлын судалгааг улсын хэмжээнд хийж, жагсаалт гарган, тархацыг тогтоож, энэ талаархи мэдээллийг цагдаа болон тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

2.4. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

2.4.1. тухайн жилд мал эмнэлгийн зориулалтаар

импортлохоор төлөвлөсөн болон импортолж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын талаархи мэдээллийг холбогдох баримтын хуулбарын хамт мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагад тухай бүрт хүргүүлэх;

2.4.2. мал эмнэлгийн зориулалтаар импортоор оруулсан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зарцуулалт, борлуулалтад цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарч хяналт шалгалт хийх.

## 2.5. Тануулын байгууллага:

2.5.1. мансууруулах, сэтгэцэд нөлөөт ургамлын тархац, хүн болон мал эмнэлгийн зориулалтаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг импортоор оруулах тусгай зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгжийн талаар байгаль орчин, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох гэрээ, баримт бичиг, мэдээллийг хүлээн авч, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах;

2.5.2. хөрш зэргэлдээ болон бүс нутаг, олон улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдлын тухай мэдээ, мэдээллээр холбогдох бусад байгууллагыг хангах.

## 2.6. Цагдаагийн байгууллага:

2.6.1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан улсуудын холбогдох байгууллагатай мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг импортоор оруулах хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн талаархи мэдээллийг солилцон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад холбогдох мэдээллийг хүргүүлэх;

2.6.2. эрүүл мэндийн болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн гэрээ, баримт бичиг, мэдээллийг хүлээн авч, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

2.6.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд, мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисын импорт, тээвэрлэлтийн талаар гэрээ, мэргэжлийн хяналтын байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах;



2.6.4. мансуурах донтой этгээд болон өвчний улмаас хараат болсон иргэдийн талаархи мэдээллийг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн авч, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

## 2.7. Гаалийн байгууллага:

2.7.1. ямар байгууллага, аж ахуйн нэгж хаанаас, хэзээ, ямар хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд, мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг ямар хилийн боомтоор нэвтрүүлсэн талаархи мэдээллийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6.5-д заасан хугацаанд мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх;

2.7.2. шаардлагатай бол хүн, мал эмнэлгийн зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд сэжигтэй байдал илэрсэн тохиолдолд мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагын холбогдох ажилтныг оролцуулах.

## 2.8. Хил хамгаалах байгууллага:

2.8.1. байгаль орчин болон мэргэжлийн хяналтын байгууллагаас ирүүлсэн хилийн бүс нутаг дахь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт ургамлын тархацын талаархи мэдээллийг хилийн таниуулын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, түүнд хяналт тавих;

2.8.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлж, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах;

2.8.3. хил орчмын нутаг дэвсгэр дэх энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээллийг цагдаа, та нуулын байгууллагад тухай бүрт хүргүүлж, мэдээлэл солилцон хамтран ажиллах.

## 2.9. Мэргэжлийн хяналтын байгууллага:

2.9.1. шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллагаас ирүүлсэн баримт материалыг үндэслэн ямар байгууллага, аж ахуйн нэгж хаанаас, хэзээ, ямар тоо хэмжээтэй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон мансууруулах бодисын үйлдвэрлэлд ашиглагддаг бодисыг ямар хилийн боомтоор нэвтрүүлсэн талаархи

мэдээллийг цагдаа, тагнуулын байгууллагад хүргүүлж, хамтран ажиллах;

2.9.2. хүн болон мал эмнэлгийн зориулалтаар улсын хи-пээр нэвтрүүлсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон тэдгээрийн түүхий эдийн импорт, экспорт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, худалдаа, түгээлт, олголт, зарцуулалт, хэрэглээнд хяналт тавьж, цагдаагийн байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллах.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Дугаар 281

Улаанбаатар  
хот

### Дүрэм, журам шинэчлэн батлах тухай

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 46.1, 46.2, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын сорьцын хяналтын дүрэм"-ийг 1 дүгээр, "Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 245 дугаар тогтоол, "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1998 оны 3 дугаар сарын 20- ны өдрийн 33 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД

Н.АЛТАНХУЯГ

Засгийн газрын 2010 оны 281 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### МОНГОЛ УЛСЫН СОРЬЦЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын сорьцын хяналт (цаашид "сорьцын хяналт" гэх)-ын зорилго нь Монгол Улсад үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн



сорьц тогтоож баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээр (цаашид "эрдэнэс" гэх)-ийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахад оршино.

1.2. Сорьцын хяналтыг улсын хэмжээнд сорьцын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

1.3. Сорьцын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Гцаашид сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага" гэх/-ын дарга нь сорьцын хяналтын улсын ерөнхий байцаагч, сорьцын хяналтын асуудал хариуцсан нэгжийн дарга нь улсын ахлах байцаагч байна. Сорьцын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг сорьцын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

1.4. Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага нь үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох лабораториуд, үнэт металл хайлах хэсэг, улсын байцаагчдаас бүрдэнэ. Орон нутагт үнэт металлын сорьц тогтоох лаборатори байгуулан ажиллуулж болно.

1.5. Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох лабораториуд нь итгэмжлэгдсэн байна. Лаборатори нь шинжилгээний дүнг батлах тусгай тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.6. Сорьцын хяналтын улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, энэхүү дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон ажиллана.

1.7. Сорьцын хяналтын улсын байцаагч нь үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.8. Сорьцын хяналтын улсын байцаагч нь үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох асуудлаар мэргэшсэн, сорьцын хяналт шалгалтын ажилд дадлагдажсан байвал зохино.

1.9. Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага нь орон нутагт ажиллаж байгаа улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь нэгдсэн дүгнэлт гарган, холбогдох арга хэмжээ авч ажиллана.



Хоёр, Сорьцын хяналтын үйл ажиллагааны хамрах хүрээ

2.1. Монгол Улсад үйлдвэрлэх үнэт металлаар хийсэн эдлэл нь ISO 9202:1991 стандартыг үндэслэн дор дурдсан сорьцтой байна:

а/ платинан эдлэл	850	/найман зуун тавь/
платинан эдлэл	900	/есөн зуу/
платинан эдлэл	950	/есөн зуун тавь/
б/ алтан эдлэл	333	/гурван зуун гучин гурав/
алтан эдлэл	375	/гурван зуун далан тавь/
алтан эдлэл	585	/таван зуун наян тавь/
алтан эдлэл	750	/долоон зуун тавь/
алтан эдлэл	916	/есөн зуун арван зургаа/
алтан эдлэл	960	/есөн зуун жарь/
в/ мөнгөн эдлэл	800	/найман зуу/
мөнгөн эдлэл	835	/найман зуун гучин тавь/
мөнгөн эдлэл	875	/найман зуун далан тавь/
мөнгөн эдлэл	925	/есөн зуун хорин тавь/
г/ палладийн эдлэл	500	/таван зуу/
палладийн эдлэл	950	/есөн зуун тавь/

д/ тусгай зориулалт болон захиалгаар хийх эдлэлийг 999 /есөн зуун ерэн ес/ сорьцтой үйлдвэрлэж болно.

2.2. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох шөнжилгээг үнэт металлын сорьц тогтоох лабораторид хийнэ. Үнэт металлаар хийсэн эдлэлд энэхүү дүрмийн 2.1-д заасан сорьцын баталгавны цифр бүхий тусгай тэмдэг /клейм/-ийг дарж баталгаажуулна.

2.3. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийг дараахь байдлаар баталгаажуулна:

-хэрэв уг эдлэл нь хоёр буюу түүнээс дээш хэсгээс бүрдэж хэсэг тус бүрийг өөр сорьцоор үйлдвэрлэсэн бол тухайн хэсэг тус бүрийн сорьцыг тогтоон бага сорьцыг дарна;

-хэрэв уг эдлэлийг хоёр буюу түүнээс дээш төрлийн үнэт металлаар үйлдвэрлэсэн бол металл тус бүрийн сорьцыг тогтоож, тухайн металл дээр нь сорьц дарах боломжгүй бол аль дарж болох хэсэг, төрөл дээр нь хоёр сорьцыг дарна.



2.4. Монгол Улсын эрдэнэсийн санд худалдан авах үнэт металлын сорьцыг тогтоож, эрдэнийн чулууг тодорхойлж баталгаажуулалт хийнэ.

2.5. Бүх төрлийн үнэт металлаар хийсэн утас, хуудас болон багаж хэрэгсэл тэдгээрийн эд ангийг үйлдвэрлэл, техникийн шаардлагын дагуу энэхүү дүрэмд заагаагүй сорьцоор үйлдвэрлэж болно.

2.6. Түүх, соёлын дурсгалт зүйл, археологийн олдвор, байгалийн төрц үнэт металлд сорьцын баталгааны тэмдэг дарахгүй байж болно.

2.7. Сорьцын улсын хяналтыг дараахь үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ:

2.7.1. эрдэнэс олборлолтын бүртгэл нь зохих хууль тогтоомжийн дагуу хийгдэж байгаа эсэх;

2.7.2. байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үнэт металлаар үйлдвэрлэсэн эдлэлийн сорьц нь энэ дүрмийн 2.1-д заасан стандартад тохирч байгаа эсэх;

2.7.3. байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрдэнийн чулуугаар үйлдвэрлэсэн эдлэлийн тодорхойлолт нь үнэн эсэх;

2.7.4. импортоор оруулж ирсэн эрдэнэсийн сорьц, эрдэнийн чулууны тодорхойлолт нь худалдааны гэрээ болон гэрээнд заасан сорьцын баталгааны тэмдэг, эрдэнийн чулууны тодорхойлолттой тохирч байгаа эсэх;

2.7.5. шаардлагатай бол эрдэнэсээр хийсэн үнэт эдлэлийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах тодорхойлолт буюу шинжээчийн дүгнэлтийг гаргах;

2.7.6. үнэт эдлэлийн сорьцын баталгааны болон үйлдвэрлэгчийн барааны тэмдгийн хэв загвар, дардсыг магадлан шалгах;

2.7.7. үнэт металлын сорьц тогтоох шинжилгээний дүн, эрдэнийн чулуу тодорхойлсон талаар гарсан маргааныг таслан магадлах /экспертийн/ шинжилгээ хийх;

2.7.8. эрдэнэсээр хийсэн эдлэлийн бүртгэлд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл нь хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад хамрагдсан эсэх.



### Гурав. Сорьцын хяналтын улсын байцаагчийн бүрэн эрх

3.1. Сорьцын хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна энэ дүрмийн 2.7-д заасан хяналтыг хэрэгжүүлж, сорьц тогтоох шаардлагатай эдлэлийг үнэт металлын сорьц тогтоох лабораторид шилжүүлж шалгуулах.

### Дөрөв. Хариуцлага

4.1. Энэ дүрмийн заалтыг зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд сорьцын хяналтын улсын байцаагч хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн албан тушаалтан хугацаанд нь биелүүлж хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

4.3. Сорьцын хяналтын улсын байцаагчийн тавьсан акт, торгууль, албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг хүлээн авсан этгээд гомдлоо улсын ерөнхий байцаагчид тавина. Улсын ерөнхий байцаагч асуудлыг хянан үзээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариу өгөх үүрэгтэй.

4.4. Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын үйл ажиллагаа, улсын байцаагчтай холбоотой гомдлыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.5. Сорьцын хяналтын улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор гүйцэтгээгүй, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

**Засгийн газрын 2010 оны 281 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт**

### **ҮНЭТ МЕТАЛЛЫН СОРЬЦ ТОГТООХ, БАТАЛГААЖУУЛАХ, ЭРДЭНИЙН ЧУЛУУ ТОДОРХОЙЛОХ, ТЭДГЭЭРИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох, шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлж гэрчилгээ



олгох, үнэт металл хайлж гулдмайлах, эдгээр үйл ажиллагааны бүртгэлийг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлийн сорьц тогтоох шинжилгээ хийх, баталгаажуулах, эрдэнийн чулуу тодорхойлж гэрчилгээ олгох, үнэт металлыг хайлж гулдмайлах ажлыг сорьцын хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллага" гэх/ хийнэ.

1.3. Үнэт металл, эрдэнийн чулуу (цаашид "эрдэнэс" гэх) олборлогч, үйлдвэрлэгч, арилжаалагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 46.1, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15.1 дэх хэсгийг баримтлан сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагаар үнэт металлын сорьц тогтоолгож, эрдэнийн чулууг тодорхойлуулан баталгаажуулна.

1.4 Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа сорьцын баталгааны тэмдэг бүхий, үйлдвэрлэгчийн барааны болон тухайн улсын сорьцын баталгааны тэмдэгтэйгээс бусад үнэт эдлэлийг сорьцын баталгаагүй гэж үзнэ. Сорьцын баталгаагүй эдлэлийг сорьц тогтоох шинжилгээнд хамруулж баталгаажуулна.

Хоёр. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах, сорьц тогтоох шинжилгээ хийх, эрдэнэсийг баталгаажуулах

2.1. Үнэт металл, тэдгээрээр хийсэн эдлэлээс дээж авах, сорьц тогтоох шинжилгээ хийх, эрдэнэсийг баталгаажуулах үйл ажиллагааг үнэт металлын сорьц тогтоох лаборатори хийж гүйцэтгэнэ. Лаборатори нь сорьц тогтоох шинжилгээний дүнг актаар баталгаажуулна.

2.2. Сорьц тогтоох шинжилгээний дээжийг гулдмай, эдлэлийн үндсэн хайлшийг төлөөлж чадах хэсгээс дараахь байдлаар авна:

2.2.1. үнэт металл гулдмай болон томоохон цул эдлэлээс өрөмдөж, хөндий болон нарийн хийцтэй эдлэлийн бүрдэл болох жижиг хэсгээс тасалж, задгай утасны хоёр үзүүрээс тасалж, ороолттой утасны задгай талын үзүүрээс хоорондоо 1 метр зайтай хэсгээс тасалж, дэвтэрлэсэн хуудас үнэт металлын аль нэг хуудаснаас тасалж, хэт жижиг бутархай хэсгүүдийг нэгтгэн хайлуулсны дараа тасалж, нунтаг тоосонцор байдалтай бол хольж хутган ижил хэсгүүдэд хувааж түүний аль нэг хэсгээс таслах байдлаар дээж авна;

2.2.2. томоохон цул эдлэл, гулдмайнаас дээж авах цэгийг дараахь байдлаар тодорхойлж өрөмдөж авна:



2.2.2.1. 6000 граммаас дээш жинтэй гулдмайн дээд болон доод талын хоёр өнцгийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс цутгамлын зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж, цутгамлын дээд болон доод талаас солбиж тус бүр хоёр дээж;

2.2.2.2. 100-6000 грамм хүртэл жинтэй гулдмайн дээд доод талын хоёр булангийн диагоналийн уртын дөрөвний нэгтэй тэнцэх хэсгээс гулдмайн зузааны хоёрны нэг хүртэл гүн өрөмдөж цутгамлын дээд, доод талаас солбиж тус бүр нэг дээж;

2.2.2.3. 100 грамм хүртэл жинтэй гулдмай, цутгамал буюу бүхэл хэсгийн голыг нэвт өрөмдөж.

2.3. Сорьц тогтоох химийн шинжилгээг олон улсын стандарт /ISO 1725/-ын шаардлагад нийцүүлэн баталсан аргачлалаар, улсын болон байгууллагын стандартын дагуу хийнэ.

2.4. Аж ахуйн нэгж, иргэдээс сорьц тогтоолгохоор нэг удаа ирүүлсэн гулдмай бүрт, үнэт эдлэлийн нэг төрлийн 100 ширхэг тутмаас нэг ширхэг эдлэлд, нэг төрлийн эдлэл нь 100 ширхэгт хүрэхгүй байвал ирүүлсэн тооны эдлэл тутмаас нэг ширхэг эдлэлд химийн шинжилгээ хийнэ.

2.5. Сорьц тогтоох химийн шинжилгээний үр дүнг үндэслэн стандартын сорьцод охирсон үнэт эдлэлийг рентгенофлюоресценцийн аппаратаар нэгбүрчлэн шалгасны дараа сорьцын баталгааны тохирох тэмдгийг дарж баталгаажуулна.

2.6. Үнэт металлаар хийсэн эдлэлийн сорьцын зөрүүний хэлбэлзэл нь 2 сорьцоос илүүгүй байна. Тухайн эдлэлийн шинжилгээний дүн стандартын сорьцод хүрэхгүй байвал үнэт эдлэлийг битүүмжлэн үл борлуулах нөхцөлтэйгээр үйлчлүүлэгчид нь буцаан олгоно. Хэрэв үйлчлүүлэгч хүсвэл тухайн сорьцод хамгийн ойр байгаа доод сорьцоор баталгаажуулж болно.

### Гурав. Эрдэнийн чулуу тодорхойлох

3.1. Эрдэнийн чулууны ангилалд нэр заасан чулууг олборлогч, эрдэнэсийн эдлэл үйлдвэрлэгч, арилжаалагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын эрдэнийн чулууны гэрчилгээг чулууг тодорхойлох, эрхлүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан "Эрдэнийн чулууны гэрчилгээ" авна.



3.2. Эрдэнийн чулуун эдлэл эзэмшигч хүсвэл өөрийн үнэт эдлэлд эрдэнийн чулууны гэрчилгээ авч болно.

3.3. Их хэмжээний нэг төрлийн таримал /synthetic/, хиймэл, дуураймал /imitations/ чулуун шигтгээг тодорхойлуулах тохиолдолд тухайн чулууны засалтын хэлбэр, хэмжээгээр нь төрөлжүүлэн ялгаж, тэдгээрээс төлөөлүүлэн дээж авч тодорхойлж болно.

3.4. Эрдэнийн чулууны гэрчилгээ нь зөвхөн тухайн үед тодорхойлуулсан чулуу, чулуун эдлэлийн хувьд хүчинтэй байх бөгөөд уг гэрчилгээг өөр чулуу, эдлэлд ашиглахыг хориглоно.

3.5. Эрдэнийн чулууны гэрчилгээ үнэн зөв болохыг уг чулуу, эдлэлийг тодорхойлсон шинжээч өөрөө хариуцна.

3.6. Гоёл чимэглэлийн үйлдвэр нь үнэт эдлэлд суулгах чулуун шигтгээг эдлэл дээрээ суулгахаас өмнө тодорхойлуулсан байвал зохино.

#### Дөрөв. Үнэт металлыг хайлж гулдмайлах

4.1. Үнэт металлыг сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагад хайлж гулдмайлна. Гулдмайн хэмжээ 12.5 кг-аас илүүгүй байна. Нөөц ихтэй томоохон ордыг ашиглаж байгаа уурхайн үйлдвэрлэлийн дамжлагад цэвэршүүлэх цех ажиллаж байгаа тохиолдолд уг аж ахуйн нэгж нь үнэт металл хайлуулах зуух ажиллуулж болно.

4.2. Үнэт металлыг хайлсан цех энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Үнэт металл хайлсан тухай акт" бичиж, тухайн аж ахуйн нэгжийн гулдмайн дугаарыг гулдмай тус бүрт тавина.

#### Тав. Үнэт металл, эрдэнийн чулууны бүртгэл тооцоо

5.1. Үнэт металл олборлогч аж ахуйн нэгж нь олборлосон үнэт металлын мэдээг энэхүү журмын 3 дугаар хавсралтаар баталсан "Үнэт металл олборлолтын журнал"-д бүртгэнэ. Журналыг тухайн уурхайн үнэт металл хүлээн авах комисс хөтөлж, хадгална.

5.2. Аж ахуйн нэгж нь үнэт металл олборлолтын жилийн тайланг энэхүү журмын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу гаргаж, Үнэт металл олборлолтын журналын хамт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагад хүргүүлж хянуулна.

Зургаа. Үнэт металл, эрдэнийн чулууны ангилал

6.1. Үнэт металл нь дараахь ангилалтай байна:

6.1.1. Алт Gold

6.1.2. Мөнгө Silver

6.1.3. Платина, платины бүлгийн металлууд /Палладий, иридий, родий, рутений, осмий/.

6.2. Эрдэнийн чулуу нь дараахь ангилалтай байна:

6.2.1 Үнэт чулуу

- |              |          |
|--------------|----------|
| 1. Доржлалам | Diamond  |
| 2. Маргад    | Emerald  |
| 3. Бадмаараг | Ruby     |
| 4. Индраанил | Sapphire |
| 5. Сувд      | Pearl    |

6.2.2 Хагас үнэт чулуу

- |  |               |
|--|---------------|
| 1. Хувилгаан эрдэнэ                    | Alexandrite   |
| 2. Улбар шар, ногоон, нил ягаан сапфир | Sapphire      |
| 3. Эрдэнийн гэрэлт чимэд               | Precious opal |
| 4. Эрдэнийн жадеит                     | Jadeite       |
| 5. Демантоид                           | Demantoid     |
| 6. Шпинель                             | Spinel        |
| 7. Гэрэлт чимэд                        | Opal          |
| 8. Усан биндэръяа                      | Aquamarine    |
| 9. Молор                               | Topaz         |
| 10. Родолит                            | Rhodolite     |
| 11. Галтмар                            | Tourmaline    |
| 12. Хризолит                           | Peridot       |
| 13. Циркон                             | Zircon        |
| 14. Биндэръяа                          | Beryl         |
| 15. Кунцит                             | Kunzite       |
| 16. Нил эрдэнэ                         | Amethyst      |
| 17. Оюу                                | Turquoise     |
| 18. Пироп                              | Pyrope        |
| 19. Альмандин /анар/                   | Almandine     |
| 20. Саран чулуу                        | Moonstone     |
| 21. Ногоон мана                        | Chrysoprase   |
| 22. Цагаг, болжр                       | Citrine       |
| 23. Ягаан болор                        | Rose quartz   |



## 6.2.3 Гоёл чимэглэлийн чулуу

1. Номин	Lapis lazuli
2. Жадеит	Jadeite
3. Хаш	Neprite
4. Шүр	Coral
5. Усан болор	Rock crustal
6. Утаат болор	Smoky quartz
7. Чароит	Charoite
8. Мана, гаргаам	Agat
9. Амазонит	Amozonite
10. Хув	Amber
11. Хар мана	Onyx
12. Үүрийн туяа	Rhodonite
13. Гематит	Hematite
14. Обсидан	Obsidan
15. Ундрам	Aventurine
16. Барын нүд	Tiger's eye
17. Муурын нүд	Cat's eye
18. Шонхорын нүд	Hawk's eye
19. Танзанит	Tanzanite
20. Ногоолин	Malachite
21. Родохрозит	Rhodochrosite

## 6.2.4 Өнгөлгөөний чулуу

1. Хас	Jasper
2. Боржин	Granite
3. Чулуужсан мод	Fossilized wood
4. Гантиг	Marble
5. Галт уулын шил	Moldavite
6. Жонш	Fluorite
7. Баргилт	Agalmatolite

6.2.5. Дээрх ангилалд нэр дурдагдаагүй чулууг ижил шинж чанартай чулууны адилар тооцно.

## Долоо. Бусад зүйл

7.1. Сорьцын хяналтын асуудал хариуцсан байгууллагын улсын байцаагч, шинжээч, ажилтан үүрэгт ажлаа буруу хийсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтан, иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сорьцын хяналтын улсын байцаагч хариуцлага хүлээлгэнэ.





Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах,  
эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх  
журмын 1 дүгээр хавсралт

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
СОРЬЦЫН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС  
ЭРДЭНИЙН ЧУЛУУНЫ ГЭРЧИЛГЭЭ

№ .....

..... он .....сар ..... өдөр

Ерөнхий тэмдэглэл.

Тодорхойлолт

Засалт

Хэлбэр

Хэмжээ

Жин

Үр дүн

Гарал үүсэл

/Эрдэнийн чулууны шинжээчийн  
нэр, гарын үсэг, тэмдэг/



Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах,  
эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх  
журмын 2 дугаар хавсралт

АКТ № ...

.....  
/байгууллагын нэр/

.....оны .... сарын .....-ны өдөр

Үнэт металл хайлсан тухай акт

№	Үнэт металлын нэр	Хайлалтын өмнөх жин	Хайлалтын дараахь жин	Хайлалтаас эргүүлж авсан шаар /шлак/-ын жин	Хайлалтын хорогдол	Тайлбар
1	2	3	4	5	6	7

Тайлбар: Гулдмай тус бүр дээр хайлалтын дугаар тавина.  
Үнэт металл хайлагч .....

Үнэт металл хайлахад байлцсан уурхайн  
комиссын гишүүд .....

Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах,  
эрдэнийн чулуу тодорхойлох, тэдгээрийг бүртгэх  
журмын 3 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ ОЛБОРЛОЛТЫН ЖУРНАЛ

/бохир жин, граммаар/

№	Он, сар, өдөр	Угаах төхөөрөмжийн нэр	Шлюзээс авсан металлтай элсний хэмжээ	Ангилал угаалтын дараахь металлын жин	Аюуны боловсруулалт хийсний дараахь		Бөсөн дүнгээр металлын жин	Угаач, үлээгчийн гарын үсэг	Комиссын гишүүдийн гарын үсэг
					Металлын жин	Хар шлюжийн жин			



Үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, эрдэний чулуу  
 тодорхойлох, тэдгээрийг бүртгэх журмын 4 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ ОЛБОРЛОЛТЫН ЖИЛИЙН ТАЙЛАН

Аж ахуйн нэгжийн нэр

Олборлогч аж ахуйн нэгжүүд жил бүрийн 2 дугаар сарын 15-ны  
 дотор Сорьцын хяналтын хэлтэст ирүүлнэ

Регистрийн №

..... оны .... сарын ....-ны өдөр

/жиш граммээр/

№	Олборлолт		Боловсруулалт				Лабораторийн шинжилгээ				Улсын эрдэнэсийн санд худалдсан байдал		Үлгэрлэл	Тайлбар			
	Олборлосон хугацаа ...сарын...өдрөг ...сарын...өдрөг	Үнэт металлын хэр шилхийн жин	Металл хүлээн авсан комиссын акт, журмалаар хүлээн авсан жин	Металл хайлсан байгууллын нэр	Хайлалтын дараахь гүлэмийн тоо	Хайлалтын өмнөх жин	Хайлалтын дараахь жин	Хайлалтын хорогдол	Тогтоосон сорьц	Тогтоосон сорьцын металлын жин	Эрдэнэсийн санд хуульчлан он, сар, өдөр	Гүлэмийн хувийн дугаар			Бохир жин	99.9 сорьцонд шилжүүлэн тооцсон жин	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18

Тайлан гэрлэсэн:

Байгууллагын дарга, захирал .....  
 Ерөнхий нягтлан бодогч .....  
 Үнэт металл хүлээн авах комисс .....

Тайланг хүлээн авсан:

Сорьцын хяналтын хэлтсийн дарга .....  
 Тамга .....  
 Улсын байцаагч .....



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2011 оны 01 дүгээр  
сарын 05-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 50 ДУГААР ЗҮЙЛИЙН 50.7 ДАХЬ ХЭСГИЙН ЗАРИМ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 12.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд П.Очирбат, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Н.Ариунболд, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Загджав нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "... эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлтийн тухай" 70 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Арлунбалд Үндсэн хуулийн цэцэг хяндалт гаргасныг мэдээлэлдээ:**



"...Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргааныг сонгуулийн дунд шатны байгууллага болох тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байхаар заажээ. Өөрөөр хэлбэл санал хураалтын дүн сонгуулийн хэсгийн болон тойргийн хэмжээнд маргаантай байгаад саналын хуудас дахин тоолуулахтай холбогдон гарсан маргааныг тойргийн хороо эцэслэн шийдвэрлэж байх хэм хэмжээ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд "тогтоогджээ".

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 19.10-т зааснаар хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд л тойргийн хорооны шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо хянан шийдвэрлэдэг ба санал хураалтын дүнгийн талаархи буюу санал дахин тоолохтой холбогдсон маргааныг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д өөрөөр заасан тул энэ төрлийн маргааныг сонгуулийн төв байгууллага авч хэлэлцэхгүй. Түүнчлэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.5-д сонгуулийн төв байгууллагын хянан шийдвэрлэх маргааныг тусгайлан заасан бөгөөд уг хэсэгт санал дахин тоолохтой холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх Сонгуулийн ерөнхий хороонд олгогдоогүй байна. ...

... Нэгэнт сонгуулийн санал хураалтын дүн буюу саналын хуудсыг дахин тоолох тухай маргааныг Сонгуулийн төв байгууллага хянан шийдвэрлэх эрх зүйн үндэслэлгүй тул тухайн асуудлаар үүссэн маргаан нь Үндсэн хуулийн цэцийн харьяаллын бус. Өөрөөр хэлбэл санал тоолох ажиллагаа нь хууль бус байснаас санал хураалтын дүнгийн талаар маргаан гарч дахин санал тоолох тухай маргаан гарвал уг асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл Үндсэн хуулийн цэцэд алга байна. ...

... Харин Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоолуулахтай холбогдсон хэрэг маргааныг шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх энэхүү шатанд эцэслэн шийдвэрлэгдэхээр заасан нь Монгол Улсын иргэний зүгээс улс төрийн эрх, эрх чөлөөгөө зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хязгаарлаж, улмаар шүүхийн "шүүх" эрх мэдлийг хязгаарласан байна. ...

... Гэвч Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан буюу санал дахин тоолохтой холбогдсон хэрэг маргаан шүүхээс өмнө маргаан урьдчилан шийдвэрлэх шатанд эцэслэн

шийдвэрлэгдэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д туссан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй", Дочин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Дочин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ..." гэсэнтэй нийцэхгүй байна." гэжээ.

**Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төмилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Загджав Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.7-д заасан "санал хураалтын дүн" гаргах ажиллагаа нь саналын хуудас тоолох ажиллагаа бөгөөд уг ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тусгайлан эрх олгосон сонгуулийн байгууллага болох хэсгийн хороонд олгосон бөгөөд өөр ямар ч байгууллагад энэхүү эрхийг олгоогүй байна.

Харин тойргийн хороо хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргадаг. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 дэх хэсэг/

Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй удаашрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан. Санал хураалтын дүнгийн талаар гарсан маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн



шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой. ...

... Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн "эцэслэн" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна." гэсэн байна.

**Гурав. 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр иргэн Н.Ариунболдоос Үндсэн хуулийн цэцэд мэдээллийн нэмэгдүүлсэн шаардлага ирүүлснийг Цэцийн гишүүн бие даасан мэдээлэл хэмээн үзсэн бөгөөд уг мэдээлэлд:**

"... Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "... эцэслэн ..." гэж заасан байгаа нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэхийг хянуулахаар гаргасан мэдээллийн шаардлагыг 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэг бүхэлдээ Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт зөрчсөн эсэхийг хянуулахаар, шаардлагын зүйлээ хянаж байгаа асуудлын хүрээнд нэмэгдүүлж байна.

...Нөгөө талаас тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага. Цэцийн гишүүний 2010 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 54 дүгээр тогтоолд дурдсанчлан тойргийн хорооны шийдвэрт гомдогч шүүхэд гомдол мэдүүлэх боломжтой байлаа ч тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал, түүнчлэн татан буугдсаных нь дараа эрх нь зөрчигдсөн тухай мэдсэн этгээд нь тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна. ..." гэжээ.

**Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Загджав 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа:**

"... Тойргийн хороо саналын хуудас тоолдоггүй бөгөөд зөвхөн тухайн тойргийн хороонд харъяалах салбар болон хэсгийн хорооны санал хураасан дүнгийн тухай шийдвэрийг үндэслэн тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг нэгтгэх үйл ажиллагаа явуулдаг сонгуулийн байгууллага юм. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16.2.10 дахь заалт/.



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.1 дэх хэсэгт "Тойргийн хороо нь салбар болон хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг хуульд заасан үзүүлэлтээр нэгтгэж, тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргана." гэж заасан. Тойргийн хороо тухайн тойргийн санал хураалтын эцсийн дүнг гаргаж байж тухайн тойрогт хамгийн олон, гэхдээ сонгогчдын 25, түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцож, түр үнэмлэх олгоно. /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3, 50.5 дахь хэсэг/. Энэ нь тойргийн хорооны бүрэн эрх бөгөөд сонгогдох эрхийн баталгаа болж байдаг онцлогтой.

Сонгуулийн санал хураалтын дүнгийн талаархи маргаан шат шатны шүүх, сонгуулийн хороодоор дамжин сунжрах, хугацаа алдах, сонгуулийн дүн гарахгүй удаашрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох, төрийн залгамж чанар алдагдах, цаашлаад төрийн гүйцэтгэх дээд байгууллагыг эмхлэн байгуулах хугацаа хойшлох, хууль ёсоор саналаа өгсөн мянга мянган сонгогчдын төлөөлөл Улсын Их Хуралд сонгогдохгүй байх, сонгогчдын эрх ашиг хохирох зэрэг сөрөг үр дагаврыг арилгах үүднээс санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Өргөдөл гаргасан иргэн Н.Ариунболдын мэдээлэлд "тойргийн хороо гэх байгууллага нь сонгуулийг зохион явуулах зорилгоор төрөөс байгуулагддаг түр ажиллагаатай байгууллага. ...тойргийн хороо нь түр ажиллагаатай тул түүнтэй шүүхээр маргалдаж байх үед татан буугдвал...тойргийн хороонд хамаарах асуудлаар шүүхэд мэдүүлэх, гомдлоо шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болдог байна" гэжээ. Санал хураалтын дүнгийн талаар аливаа маргаан гарвал тухайн тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэж байгаа нь тогтоосон тодорхой хугацаанд явагддаг сонгуулийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бөгөөд санал хураалтын дүн, түүнтэй холбоотой аливаа гомдол, маргааныг тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ гэж хугацаа зааж өгч байгаа нь харин ч түр ажиллагаатай байгууллага тул тодорхой хугацааны дотор гарсан гомдол маргааныг шийдвэрлэж байх үүрэг ногдуулсан байх тул Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн



гэж үзэх үндэслэлгүй байна.

Энд "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 05 дугаар дүгнэлтийн Үндэслэл хэсэгт "Аливаа парламентын сонгууль улс даяар нэгэн зэрэг эхэлж төвлөсөн цагт дуусгавар болдог нийтлэг зүй тогтолтой. Энэ нь сонгуулийг улс даяар нэгэн зэрэг саадгүй явуулах үндэс болдог хэмээн үздэг. Иймд сонгуулийн холбогдолтой аливаа маргааныг сонгууль явуулж дуустал шүүх болон хөндлөнгийн ямар нэгэн өөр байгууллага авч хэлэлцдэггүй журамтай байна." гэж тэмдэглэснийг онцлох нь зүйтэй гэж үзэж байна." гэсэн байна.

**Тав. Иргэн Н.Ариунболдоос Үндсэн хуулийн цэцэд хандаж 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр нэмэлт тайлбар ирүүлсэн байна. Уг нэмэлт тайлбарт:**

"... Монгол Улсад Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан хууль ёсны шударга шүүх хараат бусаар ажиллаж байгаа цагт шударга бус сонгуулийн тухай ярих нь илүүц юм. Гэвч Монгол Улсад шүүх эрх мэдлийн бүхэл бүтэн тогтолцоо ажиллаж байгаа боловч сонгуулийн холбогдолтой маргаан нь шударга шүүхийн хяналтын гадна үлджээ. Үүний нотолгоо нь 2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа түүнтэй холбоотойгоор олон тооны маргаан үүсч байсан боловч сонгуулийн холбогдолтой нэг ч маргааныг шийдэж чадсангүй эрх мэдэл нь дутлаа.

... Гэтэл санал хураалтын үр дүн, санал тооллогын дүн худлаа, хууль бус тухай мэдээлэл авсан нэр дэвшигч нь түүнчлэн сонгогч нь нотлох баримтыг (саналын хуудас болоод түүнд холбогдох баримт) шалгуулан, улмаар "сонгох, сонгогдох" эрхээ хамгаалуулахаар "дахин санал тоолуулах" тухай гомдлыг шүүхэд мэдүүлэх боломжгүй болж, гаргасан ч шүүх нь хүлээж авахгүй байх хэм хэмжээг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 50.7-д тогтоожээ. Шүүгч нь нэгэнт хуульд захирагдах ёстойгоос хойш "хуулиа" барих нь мэдээж.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай мэдээллийг шалгаж, Үндсэн хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье." гэжээ.



**Зургаа. Үндсэн хуулийн цэц энэхүү маргааныг 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Дунд суудлын хуралдаанаараа хянан хэлэлцэж, 07 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн тогтоох хэсэгт:**

"1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна." хэмээн шийдвэрлэсэн болно.

**Долоо. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 70 дугаар тогтоол гаргасан байна. Уг тогтоолд:**

"1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ...", Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна." гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Эцэ тогтоолыг 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр эхлэн дагаж мөрдсүгэй." гэсэн байна.



*Найм. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Д.Загджав 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:*

"...Иргэн Н.Ариунболдын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлтэй холбогдуулан маргааныг хянан шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч болох миний бие 2010 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 10/6984, 2010 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 10/7851 тоот албан бичгүүдээр тодорхой тайлбарыг хүргүүлсэн билээ. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд гаргах нэмэлт тайлбар байхгүй болно." гэсэн байна.

#### ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "Санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ." гэсний "...эцэслэн..." гэж заасан нь шүүхэд хандах хүний үндсэн эрхийг хязгаарласан байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "...эцэслэн" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх, ..." Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэж хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 07 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС  
ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсэгт "Санал хураалтын дунгийн талаар маргаан гарвал санал хураалт явуулсан өдрөөс хойш тойргийн хороо 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ." гэсэн заалтын "...эцэслэн..." гэснийг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн тухай Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 70 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Н.ЖАНЦАН**

**ГИШҮҮД**

**П.ОЧИРБАТ**

**Ж.АМАРСАНАА**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Ц.САРАНТУЯА**

**Д.МӨНХГЭРЭЛ**

**Б.ПҮРЭВНЯМ**

**Хаяг:**

"Төрийн мэдээлэл" мэдээллийн редакци,  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2/75

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгээс хэвлэв.  
Утас 329487